ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДГА-2024/164/НА-СТА-ТШЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.dornogovi@audit.gov.mn<br>Дорноговь аймаг Сайншанд сум<br>2024 он | Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий<br>Утас: 261665, 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn<br>Аудитын менежер: У.Оюунтүлхүүр<br>Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn<br>Ахлах аудитор/аудитор: Д.Сайнжаргал<br>Утас: 99080493 Цахим хаяг: info.iedca@gmail.com<br>Интакс Эксперт Ди Си ХХК-ийн захирал: Д.Сайнжаргал<br>Утас: 99080493 Цахим хаяг: info.iedca@gmail.com |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2024.02.23 № 1-6/226

танай ______________ -ны № ______________ -т

ЭРДЭНЭ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Г.БАТТУЯА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлыг авч үзэх бөгөөд 2023 оны боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, хөрөнгийн үр ашигтай зарцуулалт, баримтжуулалт хөрөнгө зарцуулалтын ил тод байдал, худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байуулсан эсэх, хөрөнгийн удирдлага зохион байгуулалт зэргийг гол асуудал гэж үзлээ.

Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын А тушаалыг, шилэн дансанд байршуулсан мэдээлэлтэй тулган шалгахад Хөрөнгө зарцуулах тухай 7.2 төгрөгийн үнийн дүн бүхий 24 тушаалыг шилэн дансанд байршуулаагүй байна.

Ebarimt- ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 25 ширхэг 81 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 10 ширхэг 5.2 сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байлаа. Энэ нь НББ- ийн 13.5 "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна" гэж заасны дагуу И-нэхэмжлэлд үндэслэн гүйлгээ хийсэн боловч өөрийн үйл ажиллагаанд хамааралгүй, давхардсан цахим баримтад НӨАТ-ийн тухай хуулийн 17.6 "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон бол татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэж заасны дагуу хяналт тавьж арга хэмжээ аваагүй байна.Мөн тохиолдсон байх, зохистой байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Тайлант жилд 12.6 сая төгрөгийн Samsung Galaxy Tab A8 ( Android 32 GB) таблет 14 ширхгийг шууд худалдан авсан нь төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.1 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ", 14.4 "Цахим дэлгүүрт байршсан бараа , үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэсэн заалтыг тус тус зөрчиж байна.

**Бусад асуудлын хэсэг**

АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т. ГАН-ӨЛЗИЙ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **142,072,814.10** | **238,020,456.06** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 34,489,110.88 | 122,268,067.05 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 34,489,110.88 | 122,268,067.05 |
| **3121** | **Төгрөг** | 34,489,110.88 | 122,268,067.05 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 34,489,110.88 | 122,268,067.05 |
| **33** | **АВЛАГА** | 241,090.00 | 254,412.33 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 13,322.33 |
| **335** | **Бусад авлага** | 241,090.00 | 241,090.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 241,090.00 | 241,090.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 107,342,613.22 | 115,497,976.68 |
| **351** | **Түүхий эд материал** | 34,569,473.00 | 39,246,564.96 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 32,203,178.00 | 37,014,214.96 |
| 35130 | Эм боох материал | 2,366,295.00 | 2,232,350.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 72,773,140.22 | 76,251,411.72 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 6,308,440.00 | 8,709,892.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 14,022,893.00 | 17,424,092.50 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 2,890,000.00 | 2,890,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 5,933,900.00 | 3,101,900.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,469,130.00 | 1,976,750.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 42,148,777.22 | 42,148,777.22 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,926,643,443.20** | **1,927,820,753.51** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,926,643,443.20 | 1,927,820,753.51 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,907,752,776.32 | 1,909,361,836.55 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,835,836,904.00 | 1,835,836,904.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (127,232,701.25) | (171,842,082.77) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 10,000,000.00 | 10,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (1,500,000.03) | (3,500,000.07) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 137,821,147.60 | 186,113,757.60 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (66,886,663.07) | (56,209,417.23) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 95,264,137.66 | 92,258,776.31 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (48,788,834.72) | (52,571,848.80) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 68,335,185.36 | 68,335,185.36 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (17,205,817.79) | (22,165,030.11) |
| 39217 | Ном | 22,109,418.56 | 23,105,592.26 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 18,890,666.88 | 18,458,916.96 |
| 39301 | Програм хангамж | 1,727,000.00 | 1,727,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,151,333.12) | (1,583,083.04) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 18,315,000.00 | 18,315,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,068,716,257.30** | **2,165,841,209.57** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **473,830.00** | **3,338,148.35** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 473,830.00 | 3,338,148.35 |

| | | | |
|---|---|---|---|
| **413** | **Өглөг** | 473,830.00 | 3,338,148.35 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 30.00 | 99,981.59 |
| **4136** | **Бусад өглөг** | 473,800.00 | 3,238,166.76 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 471,800.00 | 3,236,166.76 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 2,000.00 | 2,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,068,242,427.30** | **2,162,503,061.22** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,068,242,427.30 | 2,162,503,061.22 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 649,522,733.04 | 649,522,733.04 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,418,719,694.26 | 1,512,980,328.18 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,418,719,694.26 | 1,418,719,694.26 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 94,260,633.92 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,068,716,257.30** | **2,165,841,209.57** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **816,492,622.80** | **991,931,846.98** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **31,842,106.68** | **80,794,512.66** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 31,842,106.68 | 80,794,512.66 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 31,842,106.68 | 28,205,852.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 1,282,200.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,980,000.00 | 2,230,652.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 24,862,106.68 | 24,693,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | | 48,885,173.70 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | | 3,703,486.96 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **784,650,516.12** | **911,137,334.32** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 615,854,400.00 | 767,306,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 615,854,400.00 | 767,306,400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2,132,722.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,132,722.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 166,663,394.12 | 143,830,934.32 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 166,663,394.12 | 143,830,934.32 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **847,357,120.84** | **895,201,673.27** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **847,357,120.84** | **895,201,673.27** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 840,047,520.84 | 887,901,673.27 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 481,252,785.45 | 518,643,453.91 |
| 210101 | Үндсэн цалин | 380,341,017.44 | 402,294,005.76 |
| 210102 | Нэмэгдэл | 92,478,208.01 | 99,747,752.34 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 6,070,000.00 |
| 210104 | Урамшуулал | 8,433,560.00 | 10,531,695.81 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 56,673,245.76 | 70,049,534.18 |

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 37,675,240.63 | 49,417,860.90 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,815,659.21 | 5,380,617.08 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,738,925.72 | 4,867,497.72 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 861,876.10 | 923,961.43 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,581,544.10 | 9,459,597.05 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 133,486,695.12 | 143,830,934.32 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,179,694.13 | 11,965,355.71 |
| 210302 | Түлш, халаалт | 115,990,920.00 | 115,995,502.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,316,080.99 | 15,870,076.61 |
| **2105** | **Нормативт зардал** | 46,252,970.00 | 44,579,415.00 |
| 210502 | Хоол, хүнс | 46,252,970.00 | 44,579,415.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 95,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 95,000.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,130,160.00 | 4,521,700.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 1,282,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,130,160.00 | 3,239,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 117,156,664.51 | 106,276,635.86 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 23,139,279.56 | 20,290,473.76 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,836,461.26 | 2,192,438.50 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 85,180,923.69 | 83,793,723.60 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 7,309,600.00 | 7,300,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 7,309,600.00 | 7,300,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 209,600.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,100,000.00 | 7,300,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(30,864,498.04)** | **96,730,173.71** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 274,099.73 | 2,733,139.79 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 274,099.73 | 2,733,139.79 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (274,099.73) | (2,733,139.79) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(31,138,597.77)** | **93,997,033.92** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

4417144353
ЕЮА0056 9025707

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **806,836,556.12** | **914,650,186.32** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **22,186,040.00** | **3,512,852.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 22,186,040.00 | 3,512,852.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 22,186,040.00 | 3,512,852.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 1,282,200.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 8,412,200.00 | 2,230,652.00 |
| 1200047 | Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө | 13,773,840.00 | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **784,650,516.12** | **911,137,334.32** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 615,854,400.00 | 767,306,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 615,854,400.00 | 767,306,400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2,132,722.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,132,722.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 166,663,394.12 | 143,830,934.32 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 166,663,394.12 | 143,830,934.32 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **758,327,445.24** | **814,285,230.15** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **758,327,445.24** | **814,285,230.15** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **723,980,245.24** | **774,356,235.15** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 480,220,610.21 | 518,552,472.32 |
| 210101 | Үндсэн цалин | 377,176,220.16 | 372,135,479.24 |
| 210102 | Нэмэгдэл | 94,610,830.05 | 126,352,633.46 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 6,070,000.00 |
| 210104 | Урамшуулал | 8,433,560.00 | 13,994,359.62 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 56,038,699.91 | 70,053,886.51 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 38,457,646.95 | 47,122,986.51 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,526,760.08 | 5,707,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,587,688.82 | 4,566,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 818,551.43 | 1,141,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,648,052.63 | 11,515,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 133,486,695.12 | 143,830,934.32 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,179,694.13 | 11,965,355.71 |
| 210302 | Түлш, халаалт | 115,990,920.00 | 115,995,502.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,316,080.99 | 15,870,076.61 |
| **2105** | **Нормативт зардал** | 19,802,860.00 | 15,975,720.00 |
| 210502 | Хоол, хүнс | 19,802,860.00 | 15,975,720.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,053,350.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 5,053,350.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 6,543,760.00 | 3,239,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,413,600.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,130,160.00 | 3,239,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 22,834,270.00 | 22,703,722.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,192,970.00 | 15,375,972.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,641,300.00 | 7,327,750.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **34,347,200.00** | **39,928,995.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 34,347,200.00 | 39,928,995.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 27,247,200.00 | 32,628,995.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,100,000.00 | 7,300,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **48,509,110.88** | **100,364,956.17** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **14,020,000.00** | **12,586,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **14,020,000.00** | **12,586,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 14,020,000.00 | 12,586,000.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 14,020,000.00 | 12,586,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(14,020,000.00)** | **(12,586,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 34,489,110.88 | 87,778,956.17 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 34,489,110.88 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 34,489,110.88 | 122,268,067.05 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/ төгрөгөөр /

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 649,522,733.04 | 1,436,084,482.94 | 2,085,607,215.98 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | 13,773,840.00 | 13,773,840.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **649,522,733.04** | **1,449,858,322.94** | 2,099,381,055.98 |
| Тайлант үеийн үр дүн | - | (31,138,628.68) | (31,138,628.68) |
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **649,522,733.04** | **1,418,719,694.26** | 2,068,242,427.30 |
| **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **649,522,733.04** | **1,418,719,694.26** | 2,068,242,427.30 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **649,522,733.04** | **1,418,719,694.26** | 2,068,242,427.30 |
| Тайлант үеийн үр дүн | - | 94,260,633.92 | 94,260,633.92 |
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **649,522,733.04** | **1,512,980,328.18** | 2,162,503,061.22 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2.00** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 937,136,034.32 | 826,871,230.15 |
| **21.00** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 937,136,034.32 | 826,871,230.15 |
| **210.00** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 895,274,534.32 | 786,942,235.15 |
| **2,101.00** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 597,066,200.00 | 518,552,472.32 |
| 210,101.00 | Үндсэн цалин | 408,408,800.00 | 372,135,479.24 |
| 210,102.00 | Нэмэгдэл | 166,294,100.00 | 126,352,633.46 |
| 210,103.00 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 6,070,000.00 |
| 210,104.00 | Урамшуулал | 22,363,300.00 | 13,994,359.62 |
| **2,102.00** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 74,633,800.00 | 70,053,886.51 |
| 210,201.00 | Тэтгэврийн даатгал | 50,751,100.00 | 47,122,986.51 |
| 210,202.00 | Тэтгэмжийн даатгал | 5,970,700.00 | 5,707,700.00 |
| 210,203.00 | ҮОМШӨ-ний даатгал | 4,776,500.00 | 4,566,000.00 |
| 210,204.00 | Ажилгүйдлийн даатгал | 1,194,100.00 | 1,141,600.00 |
| 210,205.00 | Эрүүл мэндийн даатгал | 11,941,400.00 | 11,515,600.00 |
| **2,103.00** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 143,830,934.32 | 143,830,934.32 |
| 210,301.00 | Гэрэл, цахилгаан | 11,849,525.71 | 11,965,355.71 |
| 210,302.00 | Түлш, халаалт | 115,995,502.00 | 115,995,502.00 |
| 210,303.00 | Цэвэр, бохир ус | 15,985,906.61 | 15,870,076.61 |
| **2,105.00** | **Нормативт зардал** | 18,064,300.00 | 15,975,720.00 |
| 210,502.00 | Хоол, хүнс | 18,064,300.00 | 15,975,720.00 |
| **2,108.00** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 8,476,500.00 | 3,239,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210,801.00 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,588,000.00 | - |
| 210,806.00 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,888,500.00 | 3,239,500.00 |
| **2,109.00** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 53,202,800.00 | 35,289,722.00 |
| 210,901.00 | Бараа үйлчилгээний бусад зардал | 45,870,000.00 | 27,961,972.00 |
| 210,902.00 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,332,800.00 | 7,327,750.00 |
| **213.00** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 41,861,500.00 | 39,928,995.00 |
| **2,132.00** | **Бусад урсгал шилжүүлэг** | 41,861,500.00 | 39,928,995.00 |
| 213,205.00 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 41,861,500.00 | 32,628,995.00 |
| 213,209.00 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 7,300,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | 914,650,186.32 |
| **1,310.00** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | - | 767,306,400.00 |
| 131,001.00 | Улсын төсвөөс санхүүжих | - | 767,306,400.00 |
| **1,320.00** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | - | 143,830,934.32 |
| 132,001.00 | Орон нутгийн төсвөөс | - | 143,830,934.32 |
| **120,004.00** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | - | 3,512,852.00 |
| 1,200,041.00 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүужих | - | 1,282,200.00 |
| 1,200,042.00 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүужих | - | 2,230,652.00 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Тайлант онд нэмэлт санхүүжилт ороогүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой нийт 5,936.6 мянган төгрөгийн 4 алдаа илэрснийг аудитын явцад залруулав.

***Залруулсан алдаа:***

- Санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдлийг тулган баталгаажуулахад эхний үлдэгдэл 263.6 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлснийг залруулав.
- Хандиваар ирсэн 3,360.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг санхүүгийн системд худалдан авсан төрлөөр бүртгэсэн нь санхүүгийн тайлангуудын уялдаа холбоог шалгахад зөрүү үүсгэж байсныг залруулав.
- Хүүхдээ асарч буй чөлөөтэй эхийн нийгмийн даатгалын шимтгэлийг 2-3 сар орхигдуулан тайлагнаж нийгмийн даатгалын шимтгэлийн 1,100.0 мянган төгрөгийн өр төлбөрийг санхүүгийн тайланд буруу илэрхийлсэн.
- 7-р сард Сарангэрэлийн цалин түүнтэй адилтгах хөлсийг нийгмийн даатгалд дутуу нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөр, ХХОАТ-ийг 1,210.0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд буруу илэрхийлсэн.

Аудитаар нийт 3 зөрчил илэрснээс цаашид давтан гаргахгүй ажиллах 3 зөвлөмж өгч ажилласан.

### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

*Илрүүлэлт 1*: Ebarimt- ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 25 ширхэг 81.0 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 10 ширхэг 5.2 сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байлаа. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно. 13.5.Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна, 13.6.Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна, НӨАТ-ийн тухай хуулийн 17.6 "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон... бол татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэж заасны дагуу хяналт тавьж арга хэмжээ аваагүй байна. Мөн тохиолдсон байх, зохистой байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна

*Өгсөн зөвлөмж*: Худалдаж авсан бараа, ажил, үйлчилгээнд цахим төлбөрийн нэхэмжлэх үүсгүүлж, төлбөр төлөх үед төлбөрийн баримт үүссэн эсэхийг тогтмол хянаж байх, цахим төлбөрийн баримт олгох газруудаас худалдан авалт хийх.

*Илрүүлэлт 2*: Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын А тушаалыг, шилэн дансанд байршуулсан мэдээлэлтэй тулган шалгахад Хөрөнгө зарцуулах тухай 7.2 сая төгрөгийн 24 тушаалыг огт мэдээлээгүй байна..

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр", дагуу мэдээллийг уг хуулийн 4.1.3-т “Тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн зааалттай нийцэхгүй, зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Шилэн дансны хуулийг хэрэгжилтийг хангаж ажиллах, тогтоосон хугацаанд үнэн, зөв бүрэн байршуулж хэвших.

*Илрүүлэлт 3 TAB A8 маркын таблет 14 ширхгийг шууд худалдан авалт хийсэн байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.4.Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно* гэсэн заалттай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж :* 10.0 сая-с дээш үнийн дүн бүхий Бараа материал худалдан авахдаа дээрх хуулиудын дагуу худалдан авалтыг хийж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 08 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад

талархал илэрхийлье

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Алдааны нэгтгэл**

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл дутуу бодогдож Үр дүнгийн тайлан буруу толилуулагдсаныг залруулав. | 1 | 10,721.0 | | | 1 | 10,721.0 | 1 | 10,721.0 | | |
| Хөрөнгийн дахин үнэлгээ хийсэн боловч санхүүгийн системд журналын бичилт хийгдээгүй байсныг залруулав. | 1 | 14,570.0 | 1 | 14,570.0 | - | - | 1 | 14,570.0 | | |
| **ДҮН** | **2** | **25,291.0** | **1** | **14,570.0** | **1** | **10,721.0** | **2** | **25,291.0** | **-** | **-** |

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | |
| **ДҮН** | - | - | - | - | - | - | - | - | - | - |

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын А тушаалыг, шилэн дансанд байршуулсан мэдээлэлтэй тулган шалгахад Хөрөнгө зарцуулах тухай 2 тушаалыг хуулийн хугацааг хоцроож мэдээлсэн ба 48.8 сая төгрөгийн 4 тушаалыг огт мэдээлээгүй байна. | 1 | 48,814.4 | | | | | 1 | 48,814.4 |
| **ДҮН** | **1** | **48,814.4** | | | | | **1** | **48,814.4** |
| **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | | | |
| ЕГҮ говь ХХК, Хан музик ХХК-аас шууд худалдан авалтаар суурин компьютор, дижитал камер, Зөөврийн компьютер зэрэг үндсэн хөрөнгө худалдан авсан ба цахим дэлгүүрт хандаагүй байна. | 1 | 91,755.0 | | | | | 1 | 91,755.0 |
| Ebarimt- ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 49 ширхэг 421.9 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 11 ширхэг 95.4 сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байлаа. | 1 | 95,418.9 | | | | | 1 | 95,418.9 |
| **ДҮН** | **2** | **187,173.9** | | | | | **2** | **187,173.9** |